



БОАЖЯ-ны ХБӨБЗГ-т

“СОНОР ТРЕЙД” ХХК

Сонор Плаза
Оюутны гудамж - 2 Улаанбаатар хот 14-191
Монгол Улс

Утас: 976-11-311029

Факс: 976-11-323424

И-мэйл: sonortrade@yahoo.com

02024.03.12 *002/19*

Тайлбар хүргүүлэх тухай

Сонор трейд ХХК-ний Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Цагаанчулуутын уурхай нь 2019-2020 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа уурхайн талбайн гадна үүсгэсэн гадаад овоолго нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын засаг даргын 2012 оны 12-р сарын 27-ны өдрийн А/344 тоот захирамжтай 4306003377 тоот нэгж талбарын дугаар бүхий 6.0385га “Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламж”-ийн зориулалтаар Сонор трейд ХХК-д олгогдсон талбайн 1.5га талбайд үүсгэгдсэн талаар 2021 онд батлагдсан “Байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээ”-ний тайланд тусгагдсан байдаг.

Одоогийн байдлаар бид 2020 онд олборлолт нь дууссан ил уурхайн ёроол хэсгээс далд уурхайгаа нээж ашиглалтын үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд далд уурхайн хаалтын үед дээрх овоолгийн хоосон чулуулгийг далд уурхайн орц, гарц хэсгийг булах, тэгшлэх зэрэгт ашиглан нөлөөлөлд өртсөн талбайн хэмжээнд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөн ажиллаж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ГАНЧИМЭГ

Төлөвлөгөөний бүтэц

1.ОРШИЛ	3
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1.ТӨСЛИЙН ЗОРИЛГО.....	5
1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЗАСАГ, ЗАХИРГАА	5
1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	5
1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ	5
1.5 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙРШИЛ	5
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	8
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
3.1 ТЭРБУМ МОД.....	12
4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	143
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	143
7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	143
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	154
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	165
10.ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	17
11.ТУХАЙН ЖИЛИЙН “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
12.ТУХАЙН ЖИЛИЙН “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ” НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	19
13.“БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ.....	20

1. ОРШИЛ

“Цагаанчулуутын” аман дахь талбайд 1913-1918 он хүртэл хувь нийлүүлсэн “Монголор” нийгэмлэг, 1943-1956 онуудад Монголын уул уурхайн албан ашиглалт явуулж байсан. Энэ ордын зураглал эрэл-хайгуулын ажлыг 1950-1970 онуудад хийж байсан ба 1982 онд Монгол-Германы хамтарсан геологийн экспедиц нөөцийн судалгааг хийж, тайлан гаргасан. Манай компани 1999 онд уг ордод батлагдсан төлөвлөгөөний дагуу тодотгосон хайгуул, туршилтын ажил хийж улмаар ашиглалт явуулахаар 1817А тоот лицензийг эзэмшидэг. Манай компани Цагаанчулуутын алтны үндсэн ордыг бүрэн ашиглах зорилгоор 2011-2012 онд гарш болох барьерын целикийн баруун зүүн жигүүрийг ил аргаар олборлон авч дуусгасан ба 2018 онд ордын төв хэсгийн целик болон багануудыг ил аргаар олборлож дуусгасан.

2019-2020 онд далд аргаар ашиглах явцад хаягдсан ашиглалтын хаягдал буюу хамгаалалтын багана, карьерийн цулд үлдсэн хаягдлыг ил аргаар олборлон дуусгасан.

2019 онд батлагдсан нөөцөд үндэслэн ордыг далд аргаар ашиглах ТЭЗҮ-г “Грийн Вишн” ХХК, БОНБНҮ-г “Экологийн бүтээмж” ХХК-иар гүйцэтгүүлэн батлуулсан билээ.

Бид 2024 онд ТЭЗҮ, БОНБНҮ-д тусгагдсаны дагуу далд аргаар 3 дахь жилийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 13.14 мян.тн хүдэр олборлон боловсруулахаар үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулаад байгаа ба энэ онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу боловсруулав.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023-5-15 өдрийн тушаалын дагуу цагаанчулуутын уурхай дээр хийгдсэн уурхайн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах ажлын хэсгийн арга хэмжээний зөвлөмжийг тусган хэрэгжүүлнэ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Цагаанчулуутын” ам 1817А тоот 25 гектар хэмжээтэй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь (Зураг №1) Улаанбаатар хотоос хойш 135км, төмөр замын Баруун хараа өртөөнөөс (Баянгол сум) зүүн урагш 28км зайд оршдог.

Ордын талбай нь Хойд Хэнтийн төвийн өгөгдлийн уулархаг мужид оршдог. Рельефийн хувьд хөндий, хоолойгоор тусгаарлагдсан 900-1500м өндөрлөг газар байрлана.

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай, хуурайдуу сэрүүвтэр болон чийглэгдүү сэрүүн мужийн нэн хүйтэн дэд муж бүхий зааг нутагт оршино. Жилийн дундаж агаарын температур -1.0°C , нийлбэр хур тунадас 308мм, үүний 90% нь 5-9 сард унадаг. Жилд бороотой өдрийн тоо 50-аас дээш, цас орох өдрийн тоо 20-30 хоног тус тус байна. Хамгийн хүйтэн нь 1-р сард -40°C - -46°C , хамгийн халуун нь 7, 8-р саруудад $+36^{\circ}\text{C}$, 38°C хүрдэг. Салхины жилийн дундаж хурд 2.4м/сек, хамгийн их хурд хавар 14-24м/сек. Уурхайн орчинд 5-6м/сек хурдтай салхилдаг.

Дэд бүтцийн хувьд эрчимтэй хөгжиж байгаа төвийн бүсэд хамаарна. Тус орд нь Улаанбаатар - Сүхбаатарын хатуу хучилттай замаас зүүн зүгт 3 км зайд байрладаг. Уурхайгаас зүүн хойш 8 км зайд “Бороо гоулд” компаний алтны үйлдвэртэй. Үндсэндээ 25-90км радиус дотор сумын төвүүд, үйлдвэрийн төвлөрсөн газруудтай, асфалтан болон төмөр замтай.

Бүх төрлийн үүрэн телефоны холбоотой, интернет сүлжээнд бүрэн холбогдсон, байнгын ажиллагаатай эмнэлэг, зочид буудал, дэлгүүр ба ахуйн үйлчилгээний цэг, салбарууд бий.

Ордын ойр орчим газар тариалан, мал аж ахуй хөгжсөн.

1.1 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Сонор Трейд” ХХК нь ордыг бүрэн дүүрэн ашиглах, хаягдал багатай байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино .

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЗАСАГ, ЗАХИРГАА

“Сонор Трейд” ХХК-ний “Цагаанчулуутын” ам алтны үндсэн орд нь Засаг захиргааны харьяаллаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын гонир багын нутагт багтдаг.

1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

Хүснэгт №1

Аж ахуйн нэгжийн нэр	Латинаар	Улсын бүртгэлийн дугаар	Регистрийн дугаар
“Сонор Трейд” ХХК	“Sonor Trade” LLC	№ 9011196033	2590565

1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ

Хүснэгт №2

Аж ахуйн нэгжийн нэр	“Сонор Трейд” ХХК	
Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
	Сум/Дүүрэг	Сүхбаатар
	Баг/Хороо	8-р хороо
	Гудамж/Байр	Залуучуудын өргөн чөлөө
	Шуудангийн хайрцаг	Ш/Х-14
	Утас	311029
	Факс	976-11-323424
	Гар утас	99214188
	Электрон шуудан	sonormining@gmail.com
Захирлын хаяг	Нэр	Б. Энхболд
	Утас	311029
	Факс	976-11-323424
	Гар утас	99115698
	Электрон шуудан	sonortrade@yahoo.com

1.5 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙРШИЛ

Тус орд нь Улаанбаатар хотоос хойд зүгт 135 км, төмөр замын Баруун хараа өртөөнөөс (Баянгол сум) зүүн урагш 28 км-т орших ба Улаанбаатар - Сүхбаатарын хатуу хучилттай замаас зүүн зүгт 3 км –т байрлана.



“Цагаан чулуутын” алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг №-2

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №4

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар								
1.1	үйл ажиллагааны явцад тоосжилт үүсч хүний эрүүл мэнд болон орчны харагдах байдал мал аж ахуйн бэлчээрт салхиар дамжин сөргөөр нөлөөлөх	Далд уурхайн хувьд орчны тоосжилт харьцангуй бага ба тоосжилтын үед тухай бүрт услгаа хийнэ.	25га	-	0	0	0	Тухай бүрт	“Агаар орчны чанарын үзүүлэлт”. -Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2011-10-10-ны өдрийн А-342 дугаар тушаалаар баталсан -“Агаарын тухай” хууль, 2012 он
1.2	Техникийн утаа стандартаас ихэсч агаар бохирдуулах	Техникийн явсан мот\цагаас хамааруулж техникүүдэд засвар үйлчилгээг тогтмол хийлгэнэ	2.5га	-	0	0	0	Улирал тутамд	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 05 сарын 15-ны өдрийн А/160 тоот тушаалын дагуу ажилласан ажлын хэсгийн зөвлөмж
1.3	Шатах тослох материал уурших	Шатах тослох материалын сав баглаа боодолд хяналт тавина	0.03га	-	0	0	0	Улирал тутамд	
1.4	Цагаан тоос босох том ширхэгтэй тоосонор дэгдэх	Хаягдлын санг чийгтэй элсээр хучих	0.8га	-	0	0	0	Тухай бүрт	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц								
2.1	Түлш шатахуун, шатах тослох материал, ахуйн бохир ус асгарч алдагдах тохиолдолд бага гүнд орших уст давхаргын усыг бохирдуулах	Шатах, тослох материал алдагдахаас сэргийлж альваа үйлчилгээ тосолгоо хийхдээ зориулан бэлтгэсэн талбайд хийх асгаралтын хувин хэрэглэнэ.	0.03га	-	0	0	0	Өдөр бүр	Усны тухай” хууль, 2012 он; -“Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хууль, 2012 он; -MNS 0900:2010 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” -MNS 4943:2011
2.2	Нэгэн зэрэг бөөнөөр тэсэлсэний улмаас их хэмжээний ан, цав үүсч гүний усны эко-систем эвдэх	нэгэн зэрэг бөөнөөр тэслэхгүй хийхгүй зөвхөн /паспортын дагуу тэсэлгээний ажлыг хийнэ/	0.8га	-	0	0	0	Өдөр бүр	
2.3	Бохир ус	Бохир усны дүгнэлт гаргуулах	0.03га	-	0	0	0	Өдөр бүр	
	Уст цэгүүдийн мэдээлэл цуглуулах	Дата бааз үүсгэх							
3.	Хөрсөн бүрхэвч								
3.1	Техник хэрэгсэл эвдэрж тос масло, гидрийн шингэн , түлш зэрэг асгарч хөрсийг бохирдуулах.	Тос масло асгарахаас сэргийлж асгаралтын сав хэрэглэнэ -асгаралтын сав авна.	25га	ш	10	4	40	Өдөр бүр	-“Газрын тухай” хууль, 2012 он; “Газрын төлбөрийн тухай” хууль, 1997 он; -MNS 3473:1993 “Газар ашиглалт. Нэр томъё, тодорхойлолт”; -MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”
3.2	Олон салаа зам гаргаснаар хөрсөн бүрхэвч эвдрэх.	Одоо байгаа технологийн замыг ашгилна. - Даац хэтрүүлэн ачихаас сэргийлэн ажиллана	25га	-	0	0	0	Өдөр бүр	
3.3	Ил задгай хог хаяснаас үүдэх хөрсний бохирдол	- хог хаягдлын байгуулсан цэгт ангилан төвлрүүлэх, халдваргүйжүүлэх	25га	-	-	-	400	Жилд 1 удаа	
3.4	Гоосжилтын улмаас хөрсөн бүрхэвч эвдрэх	Тухай бүрт усалгаа хийнэ.	0.09га	рейс	0	0	0	Тухай бүрт	

	Гал түймэр гарах	Гал түймрээс урьдчилан сэргийлэх/сургалт зохион байгуулах/галын хор байршуулна Галын хор авна.	25га	ш	9	100	900	Улирал тутамд	
	Нийт						1340		
	4. Газрын хэвлий								
4.1	Далд уурхайн төлөвлөлт алдагдсанаас болж төлөвлөгдөөгүй л орон зай үүсэх.	Уулын ажлыг төлөвлөлтийн дагуу зохион байгуулах	2га	0	0	0	0	Тогтмол	Газрийн хэвлийн тухай хууль. Байгалийн ургамлын тухай” хууль, 1995 он; -“Ургамал хамгааллын тухай” хууль, 2007 он; -MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”.
4.2	Газрийн гадаргад хэт ойр буюу цөмрөлт үүсэх. Хүн, мал, амьтан унаж бэртэх.	Дөрөвдөгчийн хурдасд ойр олборлолт хийхгүй	2га	0	0	0	0	Тогтмол	
4.3	Уурхайн нөлөөгөөр нуралт суулт үүсч хохирол учруулах	Нуралт, гулсалт, суулт зэрэг аюулаас сэргийлж аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэгжүүлж ажиллана.	0.8га	0	0	0	0	Тогтмол	
4.4	Нэгэн зэрэг бөөнөөр тэсэлсэний улмаас уулын даралтыг тогтоон барьж дийлээгүй мөн их хэмжээний ан, цав үүсгэх	Тэсэлгээний ажлыг паспортын дагуу хийж дотоод хяналтыг сайжруулна.	0.8га	0	0	0	0	Тогтмол	
	5. Ургамлан нөмрөг								
5.1	Ашиглагдаж буй техник хэрэгслийн засвар үйлчилгээнээс гарч буй тос масло ууршиж тухайн орчны ургамалан бүрхүүл мал амьтанд сөргөөр нөлөөлөх.	Аюултай хог хаягдлын цэгт зориулалтын тагтай саванд хадгалж цуглуулан бүртгэж аюултай хог хаягдлыг боловсруулах албан ёсны эрх бүхий байгууллагад тушаана.	25га	0	0	0	0	Жилд 1удаа	-Байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж -Байгалийн ургамалын тухай хууль 1995 он -Ургамал хамгаалах тухай хууль 2007 он
5.2	Дур мэдэн зам гаргах	Олон салаа зам гарахаас сэргийлж сургалт зохион байгуулна	25га	0	0	0	0	Улиралд 1удаа	
5.3	Гал түймэр гарах	Галын сургалт явуулна Галын хор байршуулж ажиллана.	25га	0	0	0	0	Улиралд 1удаа	

5.4	Шимт хөрс хуулж ургамалын нөмрөг сүйтгэх	Уулын ажлын төлөвлөгөөг чанд мөрдөж ажиллана.	25га	0	0	0	0	Тогтмол	
6. Амьтны аймаг									
6.1	Үйл ажиллагааны явцад тухайн талбайн шавьж, жижиг мэрэгчид зэрэг амьтад үгүй болох	Ан амьтан ажиглалтын цэг байгуулна	25га	ш	70	1	70		- Ан амьтны тухай хууль 2012
6.2	Их дуу чимээнээс болж амьтад даажих	Хэт өндөр давтамжтай дуу гаргахгүй байх	25га	0	0	0	0		
6.3	Хүний буруутай үйл ажллагаанаас болж дүрвэх.	Ажилчдыг хүрээлэн буй орчинтой зүй зохистой харицах талаар сургалт явуулна.	25га	Удаа	0	1	0	жилд	
	Нийт						70		
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал							1410		

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сонор трейд” ХХК нь үйл ажиллагаа явуулж эхэлсэн цагаас өнөөг хүртэл хугацаанд өөрийн эзмшлийн 24га талбайн 13.18га талбайг эвдрэлд оруулж үүнээс 2021 онд 1.2 га талбайд дотоод овоолгоор дүүргэлт хийж биологийн нөхөн сэргээлт хийсэн байдаг.

Энэ онд УУХҮЯ-ны дэргэдэх АМГТГ-ын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2019 оны 12 сарын 18-ны өдөр батлагдсан нөөцийн **В-1, В-2, В-6, С-8, С-9** блокуудад олборлолт явуулах бөгөөд нийт **24610 тн** хүдэр, **25 кг** металл олборлож газрын хэвлийд 6136м² буюу 0.6га талбайг эвдрэлд оруулах ба нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ашиглалт дуусах үед уурхайн хаалтын ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ. /2024 оны төлөвлөлтийн зураг хавсаргав/


3.1 “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

Энэхүү хөдөлгөөний хүрээнд тарих модны тоог уурхай болон үйлдвэр байршиж буй байгалийн бүсчлэлийг харгалзан MNS5918:2008, байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлагын дагуу 400ширхэг модыг уурхайн хашаанд тарина. /Дэвсгэр зурагт үзүүлэв/

Зарцуулах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 07-р сарын 9-ны өдрийн А/172, 116 –рт “ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээний зардлын жишиг нормативыг шинээр болон шинчилэн батлах тухай” тушаалд зааснаар тооцов.

Хүснэгт №5

№	Нэр/төрөл	Тоо/ширхэг	Нэгж бүрийн үнэ. мян.төг	Нийт үнэ мян.төг
Мод тарих талбай 7200м ²				
1	Улиас /бусад/	400 ш	10-15	6000
2	Усалгаа	129м ³	0.773	100
3	Төмөр хашаа	Торон хашаатай		
4	Ажилтаны цалин	Дотоод нөөц боломжоор		
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний арга хэмжээний нийт зардал 6100 мян.төг				



Ерөнхий дэвсгэр Зураг3

4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалт Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ гэсэн зорилтын хүрээнд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгээгүй талбайгаас 3га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.

Энэхүү талбай нь Сэлэнгэ аймгийн ерөө суманд байрлах ба Их өлөнтийн ам нэртэй аманд байрлана.

Дүйцүүлэн хамгаалах зардалд 35 сая төгрөг төсөвлөв.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цагаанчулуутын уурхайн үндсэн ордын орчимд буюу уурхайн орчимд төслийн нөлөөлөлд өртөж нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гарахгүй учир “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах шаардлагагүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цагаанчулуутын уурхайн ашиглаж эхэлсэн үеэс өнөөг хүртэлх 10 гаруй жилийн хугацаанд ойр орчим түүх, соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд цаашид үйл ажиллагаа явуулах үед “Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй. Харин олборлолт явуулж, газрыг гүнзгийлэн ухах үед түүх, соёл, археологи, палеонтологийн холбогдолтой зүйлс илэрвэл түүнийг хамгаалалтад байлгаж, нэн даруй мэргэжлийн байгууллагад хандан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх болно.

7. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Сонор трейд” ХХК нь баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа явагдахгүй ямар нэгэн химийн бодис ашиглахгүй. Олборлолт хийхэд үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх материал ашиглах ба гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээг 2020, 2021 ондуудад хийлгэсэн. Иймээс “Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй. Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний батлагдсан нүүр хуудсыг хувиалан хавсаргав.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт № 7

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг	Баримтлах хууль, стандарт, аргачлал
<p>1. Цахилгааны тоног төхөөрөмжийг салгалгүй орхисноос гал түймэр гарах; 2. Ажиллагсдын анхаарал, санамсар байдал болгоомжгүй үйлдлээс шалтгаалж гал түймэр гарах 3. Аянга цахилгаан, аадар бороо, хүчтэй салхи, шуурганы улмаас аюул, осолд өртөх; 4. Хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг зөрчсөнөөс үйлдвэрлэлийн осолд өртөх.</p>	<p>1. Галын аюулыг бууруулах, арилгах талаар дүрэм, журам боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллага, ажилтнуудаар хянуулж, батлан мөрдөж ажиллах 2. Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулж, гал унтраах хэрэгслүүдийн ажиллагааны хэвийн байдалд хяналт тавьж тэмдэглэл хөтлөх байнгын бэлэн байлгах, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, санамж, зурагт хуудас бэлтгэж байрлуулах, мөн тохижуулах ажиллагсдыг гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж сургах;</p>	<p>2024 оны 5,10сар</p>	<p>550</p>	<p>-“Гамшгаас хамгаалах тухай” хууль, 2003 он; -“Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он; -“Галын аюулгүй байдлын тухай” хууль, 1995 он; -“Галын аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль, 2012 он; -MNS 4244-94 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”. -“Эрчим хүчний тухай” хууль, 2001 он -MNS 5151:2002 “Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа.</p>
<p>Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө нь Сонор трейд ХХК-ний Гамшгийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болон Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд бүрэн тусгагдаж хэрэгжинэ.</p>				
<p>Осол, эрсдэлийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний нийт зардал 550.0 мян.төг</p>				

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №8

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн								
1.1	Цаас, кардон	Устгана	Уурхайн бүс	тн/жил	0	0.2	0	10-р сард	
1.2	Шил, хуванцар	2-догч түүхий эд авдаг газарт нийлүүлнэ.	Уурхайн бүс	м3/жил	50	0.3	15	10-р сард	
1.3	Төмөр, лааз		Уурхайн бүс	тн/жил	50	3.5	175	10-р сард	
1.4	Холимог	Зүмдэнд төвлрүүлж сумын хог хаягдлын цэгт төвлрүүлнэ.	Уурхайн бүс	м3/жил	25	0.2	5	10-р сард	
1.5	үнс		Уурхайн бүс	м3/жил	25	5	80	10-р сард	
1.6	Бохир ус	Зүмпэнд төвлрүүлж лагыг ялгасаны дараа хөрсөнд нэвчүүлнэ.	Уурхайн бүс	Тн/жл	0	600	0	тогтмол	
	Нийт						275		
2.	Аюултай								
2.1	Тос, масло	Хаягдлын цэгт төвлрүүлж дахин боловсруулах эрх бүхий компанид нийлүүлнэ.	Уурхайн бүс	м3/жил	50	0.5	25		
2.2	аккумулятор		Уурхайн бүс	ш/жил	4	30	150		
2.3	Хуучин дугуй		Уурхайн бүс	ш/жил	5	6	50		
	Нийт						175		
	Нийт зардал						510		

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023-5-15 өдрийн тушаалын дагуу цагаанчулуутын уурхай дээр хийгдсэн уурхайн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах ажлын хэсгийн арга хэмжээний зөвлөмжийг тусган хэрэгжүүлнэ үүнд:

- Хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэгт төвлөрүүлэх түүнийг тээвэрлэх устгах ажлыг эрх бүхий байгуулагтай гэрээ байгуулан ажиллах.
- Хүрээлэн буй орчинд улирал тутамд нийтийн цэвэрлэгээ хийх, хаягдлын цэгийн ариутгал хийх.
- Аюултай хог хаягдыг бүртгүүлж дугаар авах

9.1. Аюултай хог хаягдлыг устгах, хадгалах арга хэмжээ



Зураг №5 Аюултай хог хаягдалын цэг.

3:3 харьцаатай бетонон шалтай сараалжаар хашсан аюултай хог хаягдлын цэг байгуулсан ба тос, масло, аккумулятор, тосны шүүр тэдгээрийн сав зэргийг бүртгэн авч аюултай хог хаягдлын цэгт төвлөрүүлж дахин боловсруулдаг ААН-д өгнө.

9.2. Ахуйн хог хаягдал



Зураг №6 Ахуйн шингэн хог хаягдалын цэг

Ажиллагсдын хоол үйлдвэрлэх явцад гарч буй шингэн хог хаягдлыг 3:2.5 м² харьцаатай зумфэнд цуглуулан хатуу хаягдлыг ялган шингэн хаягдлыг нэвчүүлнэ.



Ажиллагсад усанд орох, хувцас угаах, нүүр гар угаах үед ашиглагдсан бохир усыг 10м³ багтаамжтай зумфэнд хуримтлуулан лагийг дүүрсэн үед нь соруулан авах ба шингэн хаягдалыг хөрсөнд нэвчүүлэх аргыг ашиглана.

10.ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Сэлэнгэ аймгийн цаг уур орчны шижилгээний газрын байгаль орчин, хэмжилт зүйн төв лаборатори-той ажил гүйцэтгэх гэрээ байгуулж Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хяналт тавих үзүүлэлтүүдийг тогтоож, сорьц дээж авах цэгийн байршил, шинжилгээ хийх үзүүлэлтүүд, хугацаа, давтамжийг тодорхойлон хяналт-шинжилгээний ажлын үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож тусгав.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал

Хүснэгт №9

№	Хяналт шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж \удаа\	Төсөв \мян\төг
1	Хөрс	3	Үйлдвэрийн орчим, отвал , кемпын ахуйн гадна нойлын орчноос	Улиралд 1	204
2	Ус	2	Унд ахуйн гүний худаг Нуурын ус	Улиралд 1	128
3	Агаар	2	Кемпийн орчим болон Үйлдвэрийн бүсээс	Улиралд 1	66
Орчны хяналт- шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт зардал 540мян\төг					

Мониторингийн цэгүүдийн солбицол

Хүснэгт №10

Цэгийн нэр	координат		Тайлбар
	Х	У	
Хөрс №1	587556.7838	5395316.9701	План зурагт бор өнгөөр дүрслэн үзүүлэв
Хөрс №2	587254.4267	5395271.6098	
Хөрс №3	587386.1088	5395197.9772	
Ус №1	587441.2193	5395148.4028	План зурагт цэнхэр өнгөөр дүрслэн үзүүлэв
Ус №2	587223.0073	5395211.6057	
Агаар №1	587449.5549	5395314.6300	План зурагт улаан өнгөөр дүрслэн үзүүлэв
Агаар №2	587237.0388	5395305.1185	

11.ТУХАЙН ЖИЛИЙН “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

хүснэгт.№-11

Хэрэгжүүлэх ажлын нэр	Хэрэгжих газар	Хугацаа	Зардал, мян.төг	Хариуцах эзэн
Уурхайн үйл ажиллагааны явцад сум орон нутгийн иргэд болон тухайн сумаас хэрэгцээт шаардлагатай бараа материал хүнсний бүтээгдэхүүн зэргийг нийлүүлэх	Уурхайн тосгон	2024.03	-	“Сонор трейд” ХХК-ийн хяналт хариуцсан ажилтан
-Орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллагууд, нутгийн оршин суугчдад уурхайн үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл өгөх; -Тус уурхайд ажиллаж байх ажиллагсадыг сургалтанд хамруулж мэргэшүүлэх, чадавхийг нь дээшлүүлэх; -Шинээр ажиллуулахаар авч байгаа хүмүүсийг сургалтад хамруулж, шалгалт авсны дараа ажилд оруулах	Уурхайн тосгон	2024-03	-	Уурхайн дарга
Уурхайн ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Уурхайн ажиллагсад	2024-04	2500.0	Хангалт хариуцсан ажилтан
Ажиллагсдад хувийн хамгаалах хэрэгсэл /дуу чимээнээс хамгаалах чихэвч, чихний бөглөө, шүүлтүүртэй маск, бээлий цахилгаан тусгаарлагч, усны хамгаалалттай г.м-ийг олгох	Уурхайн тосгон	2024	300.0	Уурхайн захиргаа
Байгаль орчны аудит хийлгэнэ	Уурхайн тосгон	2024.12	3000	“Сонор трейд” ХХК-ийн захирал
Тэрбум мод хөтөлбөр	Уурхайн тосгон	2024.8	0	“Сонор трейд” ХХК-ийн захирал
Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал 5800.0 мян.төг				

**12.ТУХАЙН ЖИЛИЙН “БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР НӨЛӨӨЛӨЛД
ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

Хүснэгт №12

д/ д	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчилалын газарт	Бичгээр тайлагнах болон	БОМТ-ний нийт агуулгаар	11-р сард	Журманд заасны дагуу	Сэлэнгэ аймагт, уурхайн тосгонд
2	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Бичгээр тайлагнах болон	БОМТ-ний нийт агуулгаар	12-р сард	Журманд заасны дагуу	БОАЖЯ-ны байранд

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт №13

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, журам, стандарт
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах	1410	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан.
2	Техникийн болон Биологийн нөхөн сэргээлт хийх	0	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан.
3	Дүйцүүлэн хамгаалах	35000	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан.
3.1	Тэрбум мод	6100	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	Цагаанчулуутын амны алтны үндсэн ордын орчимд буюу уурхайн орчимд төслийн нөлөөлөлд өртөж нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гарахгүй учир “Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө” тусгайлан боловсруулах шаардлагагүй.	
5	Түүх, соёлын өвийг хамгаалах	Цагаанчулуутын уурхайн ашиглаж эхэлсэн үеэс өнөөг хүртэлх 10 гаруй жилийн хугацаанд ойр орчим түүх, соёлын дурсгалт зүйлс тэмдэглэгдээгүй бөгөөд цаашид үйл ажиллагаа явуулах үед “Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй. Харин олборлолт явуулж, газрыг гүнзгийлэн ухах үед түүх, соёл, археологи, палеонтологийн холбогдолтой зүйлс илэрвэл түүнийг хамгаалалтад байлгаж, нэн даруй мэргэжлийн байгууллагад хандан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх болно.	
6	Осол, эрсдэлийг бууруулах, арилгах	550	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	510	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан
8	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	5800	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	540.0	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан
10	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	300.0	Баримтлах, хууль, журам, стандартыг хэсэг тус бүрт тодорхой тусгасан
НИЙТ ЗАРДАЛ		50210мян/төг	

Хавсралт-1

1. Аж ахуй нэгж байгууллагын гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар \1817A\
3. 2023 оны далд уурхайн төлөвлөгөөний батлагдсан нүүр
4. Уурхайн ерөнхий дэвсгэр (мониторинг) зураг
5. Уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 маягт
6. ТХГН-ын тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагаа